

Чингэлтэй дүүрэг

Монгол Улсын Их хурлын тогтоолоор нийслэл хотын районуудыг хүн ам хороодынхоо тоогоор ойролцоо төвийн болон захын нийт 12 дүүрэг болгохоор тогтоов. Улсын Их хурлын 18 дугаар тогтоолоор Сүхбаатарын районыг Чингэлтэй, Сүхбаатар 2 дүүрэг болгон салгаж зохион байгуулсан. Үүнийг үндэслэн Улаанбаатар хотын АДХ-ын Тэргүүлэгчдийн 1992 оны 09 дүгэр сарын 1-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулах, дүүрэг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн үндсэн нэгж болох 18 хороотой байхаар шийдвэрлэсэн. Энэ дагуу Чингэлтэй дүүрэг нь тухайн үеийн Сүхбаатарын районы ОСГ-ын 1,7,8,11,13,14-20,28,31,32 дугаар хороод хийгээд Октябрийн районы ОСГ-ын 20, 21 дүгээр хороодод үндэслэн зохион байгуулагдсан 18 хорооноос бүрдэх болсон.

Чингэлтэй хэмээх шинэхэн дүүргийг төрүүлэн гаргаж зохион байгуулах үйл ажиллагааг тухайн үеийн Сүхбаатарын районы АДХ болон Районы гүйцэтгэх захиргаа, түүний удирдлага гардан зохион байгуулсан. Дүүргийн ИТХ-ын 1992 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэн ба дүүргийн Засаг даргаа сонгон дэвшүүлж, батлуулсанаар Чингэлтэй хэмээх шинэхэн дүүрэг албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Өрх тусгаарласан дүүрэг маань шинэ буурь сэлгэн орон гэрээ босгон төвхнөх алхамуудаа ч хийж, тэр үед ОСНАА-н компани байрлаж байсан, Сүхбаатарын гудамжны 7-р байшин Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газарт ашиглуулах шийдвэр гарч, энэ дагуу 1992 оны 10 дугаар сарын 25-ны өдөр тэнд анхлан Засаг даргын өрөөнд ганц нэгхэн албан тавилга сэлт оруулан тавьж, жижүүр ажиллуулж эхэлсэнээр туурга тусгаар айлын өрх үүд нээгдсэн, гал голомтоо бадрааж эхэлсэн. Улаанбаатар хотын Засаг даргын 1992 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/38 дугаар захирамжаар уг байрыг Чингэлтэй дүүргийн мэдэлд албан ёсоор балансаар шилжүүлсэн байна. Чингэлтэй хайрханаар овоглосон шинэ дүүрэг мэндэлсэн бөлгөө.

Дүүргийн газар нутагийн хилийн цэсийг Шарга морьтын гүүрнээс хотруу явдаг засмал замаар 32-ын тойрог хүрээд цааш гүүрнээс Дэнжийн 1000 урдуурх замаар 6-р хороололын арын уулзвараар зүүн тийш эргэн "Хүрд" компани, Монголын зохиолчдын байгууллагын тойроогоор урагшаа, Сүхбаатарын гудамжаар явж, Төв шуудангийн уулзвараар баруун тийш эргэн Энхтайваны гудамжаар баруун 4 замын уулзвар хүрэх, тэндээс их тойргоор Гэсэр сүм, түүнээс дээш өсгөх замаар Самбалхүндэв, Чингэлтэй уул, Гүнтийн давааг хярлан гарч Сэлбэ голын голдрилоор Шарга Морьтын гүүр хүрэх хэмжээнд тогтоосон байна. 1993 оны 1дүгээр сарын 23-ны өдрийн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдаанаар дүүргийн хилийн цэсийг шинэчлэн тогтоох тухай асуудлыг хэлэлцээд, Шарга морьтын гүүрнээс Дамбадаржаагийн гүүр хүртэл Сэлбэ голын гольдрилоор тогтоох саналыг нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралаар оруулан хэлэлцээд хилийн цэсэд тусган УМХ-д барьжээ. Хожим "Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тогтоох тухай УИХ-ын 1996 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор Чингэлтэй дүүргийн хилийн цэсийг дараах байдлаар тогтоосон байна.

Дүүргийн хил нь Чингэлтэй уулын 1949,7 тоот Гүнтийн даваа, Хужиртын давааны 1760,09, 17020 тоотууд, Хадлангийн даваа, Сэлбийн голоор уруудан Дамбадаржаагийн гүүр хүрч засмал замаар 7 будал 5 буудлаар дайран 32-ын тойроогоор баруун тийш эргэн Дэнжийн 1000 урд талын засмалаар явж орон сууцны 6 хорооллын арын уулзвар хүрнэ. Үүнээс зүүн тийш явж Сүхбаатарын гудамжаар урагш эргэн чиг явсаар Энхтайваны өргөн чөлөөгөөр баруун тийш явж, баруун зүүн дөрвөн замын уулзвар хүрээд, Их

тойруугаар Гэсэр сүм, Хувьсгалчдын замаар хойш эргэн Зурагтын эцсийн буудлын хойт гүүр, Мааньтын хөтөл, Хамба толгой /1686,0 тоот/ Байшинтын гозгор уул /1800,9/ тоо Чингэлтэй уул хүрэх хэмжээнд багтан оршино.1995 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж батлуулсан өдгөө хэрэглэж буй дүүргийн билэг тэмдэг буй болсон.

УИХ-ын 1992 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 18 дугар тогтоолын дагуу шинэ тутам үүсэн байгуулагдсан Чингэлтэй дүүрэгч өөрийн удирдлага, бүтэц зохион байгуулалтаа эмхлэн бүрдүүлэхээс үйл ажиллагаа эхлэв. 1992 оны 9 дүгээр сарын ихээр Чингэлтэй дүүрэгт харьяалуулахаар шийдвэрлэсэн ОСГ-ын хороодод түшиглэн хороодын Иргэдийн хурлыг амжилттай зохион байгуулсан нь нутгийн өөрөө удирдах байгууллагыг шат дараалан байгуулж, үйл ажилагааг нь эхлүүлэхэд чухал ач холобогдолтой. Хуралаар 18 хорооны 2023 иргэд оролцсон Иргэдийн хуралд сонгогдон ирсэн 95 төлөөлөгчдийн бүрэн эрхийг журмын дагуу хэлэлцээд зөвшөөрөн баталжээ. Мөн хуралаар Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн даргаар хульч Д.Тогтохжаргалыг хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар мөн районы хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Х.Төмөрийг сонгон баталжээ.